

2013 оны 5 сараас шинэчлэгдэх гэж буй гадаад иргэдийн оршин суух тухай хуулийн хатуурхал

ЧУ-ЫН ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН ГАДААД ИРГЭНД ХАМААРАХ ӨӨРЧЛӨЛТ

Дотоод явдалын яам, цагдаагаас аль нэг нь гадаад иргэн бүх хосуудын (гэрлэсэн, гэрлээгүй бүгд) харилцаа зөвхөн виз авах зорилго агуулаагүй хуурамч биш эсэхийг хянах юм байна. Гадны иргэдийг хариуцсан цагдаагийн газраас гэрт нь шалгалтаар очиж хаана унтдагийг нь харж, хөршүүдээс тэдний харилцааны талаар ямар бодолтой байгаа зэргийг асууна. Хосууд тус тусдаа нь ярилцлаганд орох ёстой ба тэдэнд хуриман дээрээ ямар өнгийн хувцастай байсан гэх мэт асууцыг тавих бололтой. Хэдэн сараас хэд хэдэн жил үргэлжилж болох өргөдлийг шалгах шийдвэрлэх хугацаанд гадаадын иргэн ажил хийх, нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдах боломжгүйгээс гадна чех иргэн улсаас тэтгэлэг хүсэх эрхгүй.

Холимог гэр бүлүүдийг ингэж гадуурхаж байгааг хүний эрхийн байгууллага, шүүхүүд эсэргүүцэж байна, **дотоод явдалын яам дараах хатууралыг санаачилж байна.**

- Чех иргэний эхнэр/нөхөр ЕХ- ны гишүүн орны иргэний гэр бүлийн гишүүнээс доор эрхтэй байгаа нь ялгаврлан гадуурхалыг харуулж байна, жишээ нь Чех нөхөртэй Укриан эмэгтэй ЕХ- ны нөлөөн доор ЧУ-д амьдардаг Словак нөхөртэй Укриан эмэгтэйдээс доогуур эрхтэй.
- Гэр бүлийн виз хүсэгч гадны иргэн өргөдлийг шийдвэрлэх хугацаанд ЧУ-ын нутаг дэвсгэрт байх эрхгүй ба өргөдлийн шийдвэр гаргал өөрийн нутагтаа хүлээх үүрэгтэй (энэ нь нөгөө талаар гэр бүлийн харилцаа салшгүй байх ёстой шаардлагыг харшилж байгаа юм)
- Хосууд албан хаагчийн асуусан асуулт бүрт хариулах үүрэгтэй ба энэ нь магадгүй гэмт хэргийн мөрдлөгд өртөх аюулыг учруулж болох талтай. Энэ тохиолдолд Үндсэн хуульд заасан өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг зөрчиж байна. Хосууд ямар нэг асуултанд хариулахаас татгалзах нь өргөдлийг автоматаар цуцлахад хүргэнэ.
- Шинэчлэгдэх гэж буй хуулиар ЧУ-ын иргэний эхнэр/нөхөрт оршин суух зөвшөөрөл олгох нь тагнуулын албанаас шууд хамаарна. Тухайн гадаадын иргэн улс, ард түмний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй талаар нууц мэдээлэл олсон тухай тагнуулын албаны мэдэгдлийг үндэслэн уг гадаадын иргэнд шалтгаан дурдалгүйгээр зөвшөөрлийг олгохоос татгалзана. Ийм тохиолдолд ЧУ-ын иргэний эхнэр/нөхөр тагнуулын албанаас ирүүлсэн мэдээлэлтэй танилцах, шийдвэрийг эсэргүүцэж шүүхэд хандах боломжгүй.

Та гадаад иргэдийн оршин суух тухай шинэ хуулийг зөвшөөрөхгүй байна уу? тийм бол бидэнтэй нэгдээрэй [na jednej.cz](http://na.jednej.cz)

Холбоо барих: office@konsorcium-nno.cz

Дэлгэрнгүйг www.migraceonline.cz/cz/temata/novy-cizinecky-zakon